

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

Хаан уулсын эцэг, хатан мөрний ижий нутаг

(аян замын тэмдэглэл)

Төвөд бол бурхны шашны өлгий нутаг. Далай лам төвөд, монголын Богд гэгээн төвөдөөс тодорч байсан. Тэнд алдарт Хималайн нуруу, дэлхийн дээвэр Жомолунгма бий. Сарлаг хэмээх үхэр Төвөдийн нэрийн хуудас. Одоо Хятадын харьяаны автомат бүс нутаг. Үүнээс илүүг бид мэдэх сэн билүү? (1)

1959 онд БНХАУ-ын харьяанд орсон, монголчуудад ойр хэрнээ холын энэ нутаг нэг хэсэг хаалттай шахуу байснаа Хятад дахь шинэчлэлийн ачаар хаалга үүдээ халти нээж, салхи савир оруулж эхэлсэн бөлгөө. (2)

Бид Бээжингээс нисэж, хоёр цаг хорин минут хэртэй аялаад Сычуань мужийн Чиндү хотод буудаллан түр амсхийв. 40 орчим минутын дараа аялал үргэлжилж, бүтэн хагас цагийн дараа Төвөдийн нийслэл Лхас хотын “Гунгаа” буудалд газардлаа. Онгоцны хаалгаар гартал толгой руу цус юүлэгдэх мэт лүгхийхийн сацуу зүрхний цохилт 100 метрт хурдалсан мэт олширч, амьсгал давчдаад сэрэх нь тэр. Улаанбаатарын хонхорт унасан миний бие (манай нийслэл далайн түвшнээс дээш 1200 метрт оршдог) нутгаасаа даруй гурав дахин өндөр 3700 метрт буюу бараг л тэнгэрт гарчхаад ийн усны загас хайрган дээр хэвтэх мэт ангалзан давчдаж буй аж. “Гунгаа” гэдэг үг нь “Бүгдийг баясгагч” гэсэн утгатай боловч “Гунгаа” буудлаас бид хэд баясах биш, бахардах шахуу болсон амьтад Лхасыг зорин хөдөллөө. (3)

Лхас гэдэг үгийг төвөдөөс орчуулбал Лха- тэнгэр, са- газар шороо, нийлээд тэнгэрийн газар болно. (4)

Лхас орчмын хөшилдсөн уулс нүцгэн хэрнээ олон өнгөтэй. Ирлэсэн гадас мэт оройтой, “зөвхөн тэнгэр лүү” гэсэн уриатай тул ургамал, модноос биедээ наах мэтийг үл ойшоосон уулс цэлдэн хөх, эсвэл хар бараандуу. Тэнгэртээ арсалдаад хүч хүрээгүйдээ уйлж байна уу гэмээр зарим уул оргилоосоо доош элсэн зураа татуулан алаглаж харагдана. Ортууз маягийн өргөст бут энд тэнд нь ургасан нь ов тов цоохор нүүртэй өвгөн шиг. Нүцгэн уулсын дундуур цоролзох ян сарьдаг мөнхийн цасан малгайгаа үдийн наранд гялалзуулж үзэгдэнэ. (5)

“Энд тэнд явж их юм үзлээ” гэдэг шиг элдвийн орон улсаар тэгтлээ их яваагүй ч Төвөд үнэхээр онцгой юм аа. Гялав цалавхийсэн өнгө үзэмж, шагшин гайхам хөгжил дэвшил, хөгжилдөө дөрлүүлсээр робот мэт болсон хүмүүс гээд өрний соёл иргэншилтэй Төвөдийг адилтгах аргагүй. (6)

Уул ус нь цаанаасаа л нэг тос нүнжигтэй, сүрдэм бишрэм. Сүм хийд, бурхан тахил нь үнэхээр л бурхны өлмийд сөгдөн байна биш үү. (7)

Ертөнц дэлхийд олон уул, уул мөрөн бий. Гэвч Хималай шиг нь, Брахмапудратай адил нь алга аа. Уулс бүхний эцэг уул, ус бүгдийн ижий мөрөнтэй, холд суугаа анд шиг минь дотнохон санагдах Төвөд орон баяртай. (8)

С.Батбаатар

Монгол хэлний даалгаврууд

1. Цогцолбор бүрд нэр өгсөн “Лхасыг зорилоо” гэдэг нэртэй нь аль вэ?
 - A. 2
 - B. 3
 - C. 6
 - D. 5

2. Эхийн дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсон нь аль вэ?
 - A. Байгалийн гоо үзэсгэлэн, сүр хүчний тухай
 - B. Аливаа зүйлээс сайхныг олж хардаг байх тухай
 - C. Алив зүйл өөрийн төрхөөрөө сайхан байдаг тухай
 - D. Хорвоо ертөнцийг танин мэдэх тухай
3. Эхийн гол утга санаанд тохирох хэлц аль вэ?
 - A. Мянга сонсохоор нэг үз
 - B. Юм үзэж нүд тайлах
 - C. Байгаль өөрөө гоо сайхны туйл
 - D. Унаган төрхөөрөө байх нь гоо сайхан
4. Зохиогч өөрийн биеэр үзсэнээ баталж нотлон, дүгнэсэн санаа аль өгүүлбэрээр илэрч байна вэ?
 - A. Улаанбаатарын хонхорт унасан миний бие нутгаасаа даруй гурав дахин өндөр 3700 метрт буюу бараг л тэнгэрт гарчхаад ийн усны загас хайрган дээр хэвтэх мэт ангалзан давчдаж буй аж.
 - B. 1959 онд БНХАУ-ын харьяанд орсон, монголчуудад ойр хэрнээ холын энэ нутаг нэг хэсэг хаалттай шахуу байснаа Хятад дахь шинэчлэлийн ачаар хаалга үүдээ халти нээж, салхи савир оруулж эхэлсэн бөлгөө.
 - C. Уул ус нь цаанаасаа л нэг тос нүнжигтэй, сүрдэм бишрэм. Сүм хийд, бурхан тахил нь үнэхээр л бурхны өлмийд сөгдөн байна биш үү.
 - D. Сарлаг хэмээх үхэр Төвөдийн нэрийн хуудас. Одоо Хятадын харьяаны автомат бүс нутаг. Үүнээс илүүг бид мэдэх сэн билүү?
5. Зохиогч санаагаа лавшруулахад “зөвхөн тэнгэр лүү гэсэн уриатай тул ургамал, модноос биедээ наах мэтийг үл ойшоосон уулс цэлдэн хөх, эсвэл хар бараандуу.” хэмээх уран дүрслэл ямар үүрэгтэй байна вэ?
 - A. адилтган дүрслэх
 - B. тойруулан дүрслэх
 - C. хэтрүүлэн дүрслэх
 - D. төлөөлөн дүрслэх
6. Үйл явдлын учир шалтгаан, үр дагаврыг тайлбарласан өгүүлбэр аль вэ? 2
 - A. Тэнгэртээ арсалдаад хүч хүрээгүйдээ уйлж байна уу гэмээр зарим уул оргилоосоо доош элсэн зураа татуулан алаглаж харагдана.
 - B. “Энд тэнд явж их юм үзлээ” гэдэг шиг элдвийн орон улсаар тэгтлээ их яваагүй ч Төвөд үнэхээр онцгой юм аа.
 - C. Ертөнц дэлхийд олон уул, уул мөрөн бий. Гэвч Хималай шиг нь, Брахмапудратай адил нь алга аа.
 - D. ... нэг хэсэг хаалттай шахуу байснаа Хятад дахь шинэчлэлийн ачаар хаалга үүдээ халти нээж, салхи савир оруулж эхэлсэн бөлгөө.
7. Зохиогчийн сэтгэгдлээ илэрхийлсэн хэсэг аль вэ?
 - A. Нүцгэн уулсын дундуур цоролзох ян сарьдаг мөнхийн цасан малгайгаа үдийн наранд гялалзуулж үзэгдэнэ.
 - B. “Энд тэнд явж их юм үзлээ” гэдэг шиг элдвийн орон улсаар тэгтлээ их яваагүй ч Төвөд үнэхээр онцгой юм аа.
 - C. ... “Гунгаа” буудлаас бид хэд баясах биш, бахардах шахуу болсон амьтад Лхасыг зорин хөдөллөө.
 - D. Уул ус нь цаанаасаа л нэг тос нүнжигтэй, сүрдэм бишрэм.

8. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг холбох нөхцөл аль вэ?
- A. хоёр цаг хорин минут хэртэй аялаад Сычуань мужийн Чиндү хотод буудаллан
 - B. хөгжилдөө дөрлүүлсээр робот мэт болсон хүмүүс **гээд** өрний соёл иргэншилтэй Төвөдийг адилтгах аргагүй.
 - C. Онгоцны хаалгаар **гартал** толгой руу цус юүлэгдэх мэт
 - D. “Гунгаа” гэдэг үг нь “Бүгдийг баясгагч” гэсэн утгатай боловч “Гунгаа” буудлаас бид хэд баясах биш, бахардах шахуу
9. Угсарсан нийлмэл өгүүлбэрийг шалтгааны утгаар холбон найруулахад аль холбох үг тохирох вэ?
- A. байтугай
 - B. болон
 - C. эсвэл
 - D. тулд
10. “Онгоцны хаалгаар гартал толгой руу цус юүлэгдэх мэт.” өгүүлбэрийн гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрээ ямар утгаар нэмэн дэлгэрүүлсэн бэ?
- A. орны утгаар
 - B. зорилгын утгаар
 - C. шалтгааны утгаар
 - D. цагийн утгаар
11. “Онгоцны хаалгаар гартал толгой руу цус юүлэгдэх мэт.” өгүүлбэрийн “хаалгаар” хэмээх үг нь өгүүлбэрт ямар гишүүн болж, аль үгтэй хэрхэн холбогдсон байна вэ?
- A. Шууд бус тусагдахуун гишүүн болж, “гартал” хэмээх үгэнд хамжиж холбогдсон.
 - B. Байц гишүүн болж, “гартал” хэмээх үгэнд найрч холбогдсон.
 - C. Шууд бус тусагдахуун гишүүн болж, “гартал” хэмээх үгэнд найрч холбогдсон.
 - D. Шууд тусагдахуун гишүүн болж, “гартал” хэмээх үгэнд хамжиж холбогдсон.
12. “Нүцгэн уулсын дундуур цоролзох ян сарьдаг мөнхийн цасан малгайгаа үдийн наранд гялалзуулж үзэгдэнэ.” нийлмэл өгүүлбэрийг зөв тодорхойлоорой.
- A. Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 - B. Тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 - C. Байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 - D. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр

Үндэсний бичгийн даалгаврууд

13. “Ийнхүү золгохдоо дүү хүн нь ямагт ахмад хүний амрыг эрэх ёстой.” өгүүлбэрийг үндэсний бичигт зөв буулгасныг олоорой.

A
 ۱. من و همسروا حسرت
 ۲. من و همسرم بن کجاست
 ۳. من و همسرم و بر من
 ۴. ملازم کجاست

B
 ۱. من و همسروا حسرت
 ۲. من و همسرم بن کجاست
 ۳. من و همسرم و بر من
 ۴. ملازم کجاست

C
 ۱. من و همسروا حسرت
 ۲. من و همسرم بن کجاست
 ۳. من و همسرم و بر من
 ۴. ملازم کجاست

D
 ۱. من و همسروا حسرت
 ۲. من و همسرم بن کجاست
 ۳. من و همسرم و بر من
 ۴. ملازم کجاست

14. “Парисын их дуулга” гэх үгийг үндэсний бичигт зөв буулгасныг олоорой.

15. Энэ хүү үг нь ямар бэлгэдэлт утгыг агуулж байна вэ

A. Ном эрдэм сурч мэдэхийг бэлгэдсэн утга

B. Элбэг чинээлэг байхыг бэлгэдсэн утга

C. Ирээдүй нь гэрэл гэгээтэй байхыг бэлгэдсэн утга

D. Эрдэм мэдлэгээр дүүрэн байхыг бэлгэдсэн утга

16. Үгийн үндсэнд -    залгаврын нийлэмж хэлбэрийг зөв залгасныг олоорой.

A
تحتکشمش

B
تحتکشمش

C
تحتکشمش

D
تحتکشمش

- 17.** Өвөрмөц бичлэгтэй үг аль нь вэ?

A B C D

Уран зохиолын даалгаврууд

18. “Махабхарата” туулийн дараах хэсэгт ямар хам сэдэв хөндөгдсөн байна вэ?

Юдхиштрад улсынхаа талыг өгсний дараа луйвраар л унагаах нь зөв гэсэн бодолдоо автан, хорон арга сэдэж, мөрийтэй тоглоом тоглоно. Мөрийд гэр орон, ард иргэд, хатнаа хүртэл алдсан Пандугийнхан шившигтэйгээр цөлөгдөнө.

- A. Шашны хам сэдэв
- B. Улс төрийн хам сэдэв
- C. Гүн ухааны хам сэдэв
- D. Түүхийн хам сэдэв

19. “Өвч биеийн сүүдэр

Эмээл дээрээ царцах нь

Өвлийн нарны илч аж.” хэмээх хайку шүлгийн далд утгыг зөв тайлбарласныг олоорой.

- A. Хүйтэн ба хувирал
- B. Хөдөлгөөн ба дэвшил
- C. Өвдөлт ба эмзэглэл
- D. Залхуурал ба мөхөл

20. “Үүлэн зардас” найраглалын дараах бадаг нь дүрийн дотоод сэтгэлийн ямар шинжийг илэрхийлж байна вэ?

Сэгхийгээд чанагш одохдоо, ойн голын эргийн гүнд цэцгийг
Сэрүүн дуслаараа сэргээгээд, цэцэг түүгч сайхан охидыг
Сэрвэгэнэн савирах хөлсөө арчсаар чихний линхув чилснийг
Сэрүүцүүлэн хоромхон ч гэсэн амрааж өгөөрэй.

- A. Бусдыг асран халамжилсан
- B. Бусдад санаа зовнисон
- C. Бусдад анхааруулан сануулсан
- D. Бусдыг өрөвдөн хайрласан

21. “Нарангэрэл дагинын тууж” дахь дараах харилцан ярианаас ямар утга тодорч байна вэ?

Жэү өвгөн өгүүлрүүн: “Бэрийн чинь чин зориг үнэний тул их нигүүлсэгчийн адистаа бэр чинь эс өвдсөн биз”. Эх нь бас хилэгнэж өгүүлрүүн: “Ай бэр чиний огтолсон ярыг би үзье” хэмээсэнд эрдэмт Нарангэрэл зүүн гараа үзүүлбээс яр нь үнэн аж.

- A. Бусдыг тэтгэн тэнхрүүлсэн
- B. Бусдыг хайрлаж энэрсэн
- C. Бусдын төлөө сэтгэл зовсон
- D. Бусдад чин үнэнч хандсан

22. “Игорийн хорооны үг” туулийн дараах хэсгийн бичил дүрслэл буюу мэдрэхүйн нарийвчлалын үр нөлөөг зөв тайлбарласан нь аль вэ?

“Олзлогдсоноос үхсэн нь дээр биш үү
Өмөг цэрэг дүү нар минь
Хөлөг хурдан мориндоо мордож
Хөх Доныг үзүүлье”

- A. “мориндоо мордох” хэмээх үгээр дайсагнасан үр нөлөөг бүтээсэн.
- B. “өмөг цэрэг” хэмээх үгээр дотночилсон үр нөлөөг бүтээсэн.
- C. “үхсэн нь дээр” хэмээх үгээр бардамнасан үр нөлөөг бүтээсэн.
- D. “хөлөг хурдан” хэмээх үгээр яаравчилсан үр нөлөөг бүтээсэн.